



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 107

Номгон

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоолд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, 25 дугаар зүйлийн 25.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоолын хавсралтын 1, 2 дугаар мөрөнд заасан хөрөнгийн эзэмшигчийг “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т гэснийг өөрчлөн “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК гэж өөрчилсүгэй.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Эзэмшигчийг өөрчилсөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

3. Уг тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоолын хавсралтын 1, 2 дугаар мөрийн хөрөнгөд эзэмшигч тогтоосныг хүчингүйд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0118095